



ИРГЭДИЙН ТӨСӨВ

төсвийн I улирлын гүйцэтгэл

Улаанбаатар хот 2019 он



Сайн байна уу.
Би Сангийн яамны мэргэжилтэн байна.
Та бүхэнд би Монгол Улсын 2019 оны төсвийн 1 дүгээр
улирлын гүйцэтгэлийн талаар тайлбарлах болно.
Та анхаарлаа хандуулна уу.



Засгийн газрын 2019 онд авч хэрэгжүүлэх бодлогыг танилцуулья



ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

Төсвийн алдагдлыг үе шаттай бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 5.4 хувьд хүргэнэ



ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

Гадаадын зээл, тусламжийг эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн үр ашигтай төсөлд зарцуулна.



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Өрийн өнөөгийн үнэ цэнэ болон дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааг 55.3% болгож, хүүгийн зардлыг бууруулна



ТӨСВИЙН ОРЛОГО

Татварын хуулийн шинэчлэл, Гаалийн шинэчлэл, Орон нутгийн орлогын шинэчлэлийг хэрэгжүүлнэ.



ТӨСВИЙН ЗАРЛАГА

Төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлж, үр ашигтай хуваарилахад технологийн дэвшлийг нэвтрүүлэн, ил тод байдлыг сайжруулна




ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үр ашгийг сайжруулснаар эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.



ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн төвлөрлийг сааруулж, орон нутгийн өмчийг эзэнд нь хариуцуулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.



За одоо эхний улирлын хэрэгжилтийг харцгаая



Төсвийн орлого - I улирлын гүйцэтгэл

ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО

Төсвийн нийт орлого Тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан болон тэнцвэржүүлсэн орлогоос тус тус бүрдэнэ



ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

Төсвийн тогтворжуулалтын сан нь дэлхийн зах зээл дээрх эрдэс, түүхий эдийн үнийн өөрчлөлтөөс хамаарсан төсвийн орлогын хэлбэлзлийг тогтворжуулах, мөн төсвийн алдагдлыг нөхөх зориулалттай.

**ТӨСВИЙН
НИЙТ ОРЛОГО**
2,433.1 тэрбум

22.0 %
өнгөрсөн оны
мөн үеэс

**ТОГТВОР
ЖУУЛАЛТЫН
САН**
13.8 тэрбум

79.0 %
өнгөрсөн оны
мөн үеэс

ИРЭЭДҮЙН ӨВ САН

Ирээдүйн өв сан нь эрдэс баялгаас бий болсон орлогын тодорхой хэсгийг ирээдүй хойч үеийнхэндээ зориулан хадгалж буй сан юм.

**ИРЭЭДҮЙН
ӨВ САН**
255.9 тэрбум

118.3 %
өнгөрсөн оны
мөн үеэс

ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО
2,163.4 тэрбум

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ОРЛОГО**
438.9 тэрбум

27.5 %
өнгөрсөн оны
мөн үеэс

20.3%

28.4%

**БУСАД ТАТВАРЫН
ОРЛОГО**

613.4 тэрбум

27.6 %
өнгөрсөн оны
мөн үеэс

**2,163.4
ТЭРБУМ ТӨГРӨГ**

өнгөрсөн оны
мөн үеэс 19.5%

8.9%

**ТАТВАРЫН БУС
ОРЛОГО**

191.9 тэрбум

0.4 %
өнгөрсөн оны
мөн үеэс

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН
АЛБАН ТАТВАР**

381.6 тэрбум

0.2 %
өнгөрсөн оны
мөн үеэс

24.9%

**ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАР**

537.6 тэрбум

30.4 %
өнгөрсөн оны
мөн үеэс

Төсвийн орлого - I улирлын гүйцэтгэл



Төсвийн орлого 2019 оны I улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 22 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд уул уурхайн салбарын орлого голлон нөлөөлсөн байна.



ОНЦЛОХ ОРЛОГО

өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

ААНОАТ
+ 30%

Газрын
тос
- 11%

АМНАТ
+ 73%

Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүний хэмжээ өссөнөөр АМНАТ болон ААНОАТ-ын орлого нэмэгдсэн.

Газрын тосны экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 10.5 мянган баррелиар, үнэ 12.6 хувиар тус тус буурсан нь газрын тосны орлого буурахад нөлөөлсөн.

УУЛ УУРХАЙН ГОЛЛОХ ЭКСПОРТЫН I УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ




Төсвийн зарлага - I улирлын гүйцэтгэл



УЛСЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ (САЛБАРААР) I улирлын гүйцэтгэл

59.2%
Нийт зардалд эзлэх



Төсвийн зарлага - I улирлын гүйцэтгэл

Засгийн газраас бие даан үйлдвэрлэл явуулах боломжгүй буюу төрөөс дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай зарим салбарт тодорхой хугацаагаар төсвийн дэмжлэг буюу татаас олгодог.

Төсвийн томоохон дэмжлэг



**УЛААН БУУДАЙН
УРАМШУУЛАЛ**

7.3 тэрбум төгрөг



**ЭРЧИМ ХҮЧНИЙ
ТАТААС**

5.3 тэрбум төгрөг



Нийгмийн халамжийн сангийн 2019 оны I улирлын гүйцэтгэлээр хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж 32%, цалинтай ээж хөтөлбөр 13%, халамжийн тэтгэвэр 15%, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмж 16%, хүнс тэжээлийн тусламж, дэмжлэг 4%, нөхцөлт мөнгөн тусламж 6%, бусад зардал нь 14%-ийг тус тус эзэлж байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН

I улирлын гүйцэтгэл

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН
172.3 тэрбум



Төсвийн зарлага - I улирлын гүйцэтгэл

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны I улирлын гүйцэтгэл 72.3 тэрбум төгрөг байна. Үүнээс 74 хувь буюу 53.6 тэрбум төгрөг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд өгөх шилжүүлэг буюу төрийн хэвшлийн эмнэлгээр үйлчлүүлж буй даатгуулагчдад үзүүлэх хөнгөлөлтөд зориулагдсан байна



Нийгмийн даатгалын сангийн зардал 2019 оны I улирлын байдлаар 97.4% гүйцэтгэлтэй байна

Төсвийн хөрөнгө оруулалт I улирлын гүйцэтгэл

**Боловсрол, соёл, шинжлэх
ухаан, спортын сайд**

7.8 тэрбум

хөрөнгийн зардалд
эзлэх хувь **13.3 %**

**Барилга, хот
байгуулалтын сайд**

10.7 тэрбум

хөрөнгийн зардалд
эзлэх хувь **18.0 %**

Хууль зүй, дотоод

хэргийн сайд
6.6 тэрбум

хөрөнгийн зардалд
эзлэх хувь **11.1 %**

Сангийн сайд
4.9 тэрбум

хөрөнгийн зардалд
эзлэх хувь **8.3 %**

**Зам, тээврийн
хөгжлийн сайд**
18.4 тэрбум

хөрөнгийн зардалд
эзлэх хувь **31.0 %**

Эрчим хүчний сайд
3.6 тэрбум

хөрөнгийн зардалд
эзлэх хувь **6.0 %**

Бусад
7.2 тэрбум

хөрөнгийн зардалд
эзлэх хувь **12.2 %**

**УЛСЫН ТӨСВИЙН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**


**59.2
тэрбум**

Засгийн газрын өр - I улирлын гүйцэтгэл




Өрийг үе шаттай бууруулах бодлого баримталж байна.

Нийт хүүгийн зардлын гүйцэтгэл /тэрбум/



Нийт үндсэн төлбөрийн гүйцэтгэл /тэрбум/



Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 2019 оны I улиралд доорх томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлсэн байна.



Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл

5.7
тэрбум



Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт

3.5
тэрбум



Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр

2.2
тэрбум



Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл

2.2
тэрбум



Инженер технологийн дээд боловсрол төсөл

1.5
тэрбум

Орон нутгийн төсөв- I улирлын гүйцэтгэл



Орон нутгийн төсөв нь Улсын төсвөөс олгож байгаа тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сан, санхүүгийн дэмжлэг болон орон нутгийн өөрийн орлогоос бүрддэг. 2019 оны 1 дүгээр улиралд бид төсвийн сахилга батыг сахиж, хариуцлагыг сайжруулсанаар Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийг цаг тухай бүрт нь төсвийн хуваарийн дагуу олгосон байна.

Сургуулийн өмнөх
боловсрол

94.2
тэрбум

Ерөнхий
боловсрол

164.5
тэрбум

Эрүүл мэндийн даатгалын
сангаас санхүүжих

2.2
тэрбум

Газрын харилцаа
кадастр

3.1
тэрбум

Эрүүл мэндийн
тусламж

32.7
тэрбум

Хүүхдийн хөгжил,
хамгаалал

2.0
тэрбум




Орон нутгийн төсвийн орлого нь зарлагаас бага буюу алдагдалтай байгаа тохиолдолд тухайн алдагдлыг нөхөх зорилгоор Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.

Санхүүгийн дэмжлэг 50.4 тэрбум



Орон нутгийн төсвийн орлого нь зарлагаас их буюу ашигтай гарсан тохиолдолд тухайн орлогын тодорхой хувийг Улсын төсөвт төвлөрүүлдэг.

Орлогын шилжүүлэг 24.0 тэрбум



Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан




2019 онд өмнөх оноос 62 хувиар нэмэгдүүлсэн

Санхүүжилтийн хэмжээ I улирлын байдлаар нийт 15.9 тэрбум төгрөг бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 30 хувиар өссөн байна



Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгосон санхүүжилт I улирлын байдлаар /сая төгрөг/



Энэ улиралд аймаг, нийслэлийн ОНХС-д нийт 15.9 тэрбум төгрөг шилжиж орсон байна. Охиныхоо цэцэрлэгийн засварыг сангийн хөрөнгөөр хийлгэхээр санал өгч батлагдсан юмсан. Тэр ажил маань аль улиралд хийгдэхээр болсон юм бол? Дүүргээсээ асуух юм байна шүү.

